

ГАЗАРЗҮЙН ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД

МУБИС - ийн докторант Ц.Мөнхбаатар

Хураангуй

Ээлжит хичээлийн технологийг шинэчлэн сайжруулахын тулд зарим хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулснаар мэдээлэл харилцааны технологийг багш, суралцагчид эзэмших чадвар, дадал төлөвших бөгөөд нэг цагт явагдах хичээлийн агуулгын багтаамжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Багш тухайн хичээлийг бэлтгэхдээ суралцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн тулгуур бүдүүвчийг боловсруулж, түүнийгээ суралцагчдын ажиглалт, судалгааны материалаар баяжуулж явуулах нь тэдний хэрэглээний чадамжийг илүү хөгжүүлэх онцлогтой.

Түлхүүр үгс: Тулгуур бүдүүвч, таарц, цахим хичээл, үзэгдэл зүйн ажиглалт

Орчин үеийн шаардлагын дагуу сургалтын үр дүнг дээшлүүлэх гол арга бол ээлжит технологийг шинэчлэн сайжруулах явдал юм.

Өнөөгийн ээлжит хичээлийг явуулж буй давуу болон сул тал эерэг ба сөрөг хандлагад хийсэн ажиглалт судалгаанд үндэслэн дүгнэлт хийж үзэхэд: Хичээлд цахим хэлбэрийг ашиглах нь илүү үр дүнтэй байна.

Газарзүйн хичээлийг цахим хэлбэрээр явуулахад тухайн сэдэвт тохирсон тулгуур бүдүүвчүүдийг хийхэд илүү үр дүнтэй юм. Жишээлбэл: "Цаг агаар түүний өөрчлөгдөх шалтгаан" сэдэвт хийсэн тулгуур бүдүүвчийг авч үзье.

Тулгуур бүдүүвчийг орон нутгийн болон суралцагчдын таарцыг тэмдэглэсэн тэмдэглэл болон ургамал, амьтан, байгалийн байдлаар ажиглалт хийж, ард түмний уламжлалт ажиглалттай харьцуулсан таарцыг үзүүлвэл:

ОРОН НУТГИЙН ШИНЖ БАЙДЛЫГ АЖИГЛАСАН АЖИГЛАЛТ БА ТААРЦ

Ажигласан үзэгдлүүд	Тохиолдолууд тоогоор	Таарц	%-иар илэрхийлбэл
Хараацай дээгүүр нисэж байвал бороо орохгүй буюу тэнгэр цэлмэг байна	20	17	85
Болжмор сүрэг сүргээрээ бөөгнөрөн дахин дахин нисэж бууж, биеэ ойр ойрхон сэгсэрвэл хүйтэрнэ	26	23	88,4
Хөхөө үргэлжлэн донгодоход тэнгэр цэлмэг болно	10	8	80

Сэдэв: Цаг агаар , түүний өөрчлөгдөх шалтгаан

Энд ?

АЦ ➡ Шилжих хөдөлгөөн

Тэнгис, эх газар

ААЦ ➡ ±


САЦ ➡ Улирал

ДАЦ ➡ +

ЭАЦ ➡ +

ААЦ - Арктикийн агаарын цул хүйтэн хуурай
САЦ - Сэрүүн бүсийн агаарын цул улирлаар өөрчлөгдөнө

Одоо ?



ДАЦ - Дулаан бүс агаарын цул халуун хуурай
ЭАЦ - Экваторын агаарын цул халуун чийглэг
АЦ - Агаарын цулын шилжих хөдөлгөөнийг цаг уурын бүх үзэгдэл өөрчлөгдөнө




Энэхүү ажиллабарыг хийснээр суралцагчид агаарын даралт ба салхины тухай ойлголтоо өөрсдийн орон нутагтаа хийсэн ажиглалтаар баяжуулан мэдлэгээ бүтээж авдаг давуу талтай юм.

Цахим хичээл явуулахын тулд ийнхүү тулгуур бүдүүвчүүдийг зохиож суралцагчдын орон нутагт хийсэн ажиглалт болон бусад материалаар баяжуулан оюун дүгнэлт хийж мэдлэг бүтээх боломжийг бүрдүүллээ. Байгалийн үзэгдэлзүйн зарчим, ухагдахууны тоон болон чанарын материалд үнэлгээ, дүгнэлт өгөх чадвар эзэмшинэ.

7р ангид 2 сарын өмнөх ердийн аргаар явуулсан бүлэг сэдэв, 2 сарын дараах цахим хэлбэрээр хичээл зохион байгуулсан бүлэг сэдвээр суралцагчдын төлөвшилд харьцуулалт хийсэн судалгаа.

Хүүхдийн хөгжлийн чадамжийн үнэлгээ



Дээрх үзүүлэлтүүдээр хүүхдийн хөгжлийн чадамжийн үнэлгээ хийж үзэхэд өмнө нь судалсан сэдвээс хоёр сарын дараа цахим хэлбэрээр хичээл хийж судалгаа авахад ерөнхий чадвар хандлага эрс сайжирсан байна.

Суралцагчид хичээлийн явцад өөртөө зорилго тавьж түүндээ хүрч чадсан эсэхийг үнэлэх. Мөн бусдын үйл ажиллагаанд хяналт тавих бусдаасаа суралцан сайныг нь авч дутууг нь шүүмжлэх, хичээлээр тавьж байгаа шаардлагад өөрөө хүрч байгаа эсэхээ хянах, багшаар үнэлүүлэх, бусдаараа үнэлүүлэх нь үнэлгээ сайн муу гэдэг асуудалдаа биш суралцагчийг хөгжиж төлөвшихөд хөтлөх үйл явц болно.

ДҮГНЭЛТ

- Цахим хичээлд тулгуур ухагдахуун болон зохиомж хийснээр хичээлийн багтаамж хэдий чинээ ихэснэ суралцагчийн цогц чадамж төдий чинээ хэмжээгээр төлөвшинө.
- Цахим хичээл нь хэрэглэгдэхүүн өргөн ашиглах боломжтой юм. Учир нь янз бүрийн зураг, схем, диаграмм, фото зураг, хүснэгт, байгалийн байдал зэрэг төрөл бүрийн материалыг техник хэрэгсэлийн тусламжтайгаар бүх суралцагчид хүрэлцэх хэмжээгээр ашиглах боломжтой бөгөөд суралцагч бүр компьютертэй ажиллаж сурна.
- Багшийн яриаг багасгаж, дэлгэц дээрээс шууд уншаад бүх талын мэдээлэл авна. Багш урьдчилан сайн бэлтгэсэн учир нэг цагийн багтаамж ихтэй. Жишээ нь самбарт шохойгоор бичнэ, үзүүлэн байрлуулна, тараах материал бэлтгэх гэх мэт цаг хэмнэгдэнэ.
- Багш хүн хичээлээ сайн болгохын тулд элдэв материал судалж оюун ухаан биеэ дайчилан мэдээлэл, харилцааны давуу талыг ойлгон өөрөө онол хэрэглээний өндөр түвшинд боловсорно.
- Орон нутаг, амьдрал ахуйн жишээг онолоор баталж, онолыг орон нутаг, ахуй судлалаар нотолж, суралцагчид онолыг хэрэглээ болгож ахуй, амьдралдаа ашиглах чадвар бий болно.

НОМЗҮЙ

- Батчулуун. Е. нар., Газарзүй – 1. Сурах бичиг. Уб., 2006.
- Батчулуун. Е. Сургуулийн газарзүйн онол – аргазүй. Уб., 2001
- Боловсрол судлал сэтгүүлүүд., 2008., 2009.
- Газарзүйн боловсролын стандарт. БСШУЯ, Бага, дунд боловсролын стандарт. Уб., 2004
- Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 7-р ангийн шилжилтийн төлөвлөгөө. Газарзүй Сургалтын хөтөлбөр зөвлөмж – 7, Уб., 2009
- Мөнхбаатар.Ц. нар., ЕБС-ын Газарзүйн сургалтын технологийг боловсронгуй болгох аргазүйн асуудал. Уб., 2008
- Шагдар.Ш. Газарзүйн хичээлээр шийдвэрлүүлэх асуудал. Уб., 2007